



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 14/76

Мандалговь

“Мандал шилтгээн” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/08 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбай” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мандал шилтгээн” ХХК-тай 234,769,883 (хоёр зуун гучин дөрвөн сая долоон зуун жаран есөн мянга найман зуун гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбай” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мандал шилтгээн” ХХК-ны захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

Гурав.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060312